



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-НИЙ 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/93/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: baterdenec@audit.gov.mn
“Мэдээлэл Аудит” ХХК-ийн
Захирал Д.Товуудорж
Утас: 70159511, 99049511
Цахим хаяг: medeelelaudit@gmail.com

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Компани/ТӨХК/, түүний үйл ажиллагаа	11
3.2 Компани/ТӨХК/-ийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
ДЭХ	Дулааны эрчим хүч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦДҮС	Цахилгаан түгээх үндэсний сүлжээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ
ТАНАА

2023.03.21 № 07/611
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Амгалан дулааны станц" ТӨХК-ийг 116МВт-ын хүчин чадалтай зуухаар өргөтгөхтэй холбоотой Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 444 дугаар "Тариф батлах тухай" тогтоолоор 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн борлуулах дулааны үнийг үе шаттайгаар нэмэгдүүлэх тариф баталсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 218 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Z:\Yawsan_Bichig\2023\0315 SNAG-46 Docx

0301051015

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛС	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
А	Б		
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	74,992,232.77	430,542,180.60
1.1.2	Дансны авлага	838,163,886.56	695,273,431.27
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	841,718.20	174,851,729.08
1.1.4	Бусад авлага	4,829,977.04	25,674,514.96
1.1.6	Бараа материал	1,290,234,172.86	1,481,011,481.63
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	282,261,425.63	379,864,566.37
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,491,323,413.06	3,187,217,903.91
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	71,803,294,474.10	66,340,579,159.93
1.2.2	Биет бус хөрөнгө	13,097,154,079.00	13,074,698,860.80
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	513,825,623.69	549,088,865.68
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	85,414,274,176.79	79,964,366,886.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	87,905,597,589.85	83,151,584,790.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,893,395,518.02	5,572,005,146.19
2.1.1.2	Цалингийн өглөг	1,107,746.00	91,500.00
2.1.1.3	Татварын өр	526,259,050.80	733,606,070.93
2.1.1.4	НДШ - ийн өглөг		324,502,019.51
2.1.1.5	Богино хугацаат зээл	333,333,333.34	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	109,081,061.07	106,188,472.12
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,863,176,709.23	6,736,393,208.75
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,729,946,676.34	2,008,501,506.90
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	906,403,853.24	799,541,361.34
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,636,350,529.58	2,808,042,868.24
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,499,527,238.81	9,544,436,076.99
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: төрийн	99,598,987,346.37	99,598,987,346.37
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,496,116,697.19	2,497,013,552.23
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	13,005,849,600.00	13,005,849,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(32,694,883,292.52)	(41,494,701,785.27)
2.3.11	Эздийн өмчийн дүн	82,406,070,351.04	73,607,148,713.33
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	87,905,597,589.85	83,151,584,790.32



2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	21,004,734,515.20	24,058,669,411.23
2	Борлуулалтын өртөг	25,738,945,281.17	30,167,019,099.64
3	Нийт ашиг (алдагдал)	(4,734,210,765.97)	(6,108,349,688.41)
4	Түрээсийн орлого	1,732,500.00	2,503,800.00
5	Хүүний орлого	752,767.23	
8	Бусад орлого	189,987,463.71	158,716,261.84
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,227,484,158.47	2,358,100,368.13
11	Санхүүгийн зардал	27,846,575.34	7,226,301.38
12	Бусад зардал	239,644,588.97	246,770,608.10
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	513,592,922.77	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(7,550,306,280.58)	(8,559,226,904.18)
19	Орлогын татварын зардал	355,937,483.65	243,291,588.57
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(7,906,243,764.23)	(8,802,518,492.75)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(7,906,243,764.23)	(8,802,518,492.75)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(24,788,639,528.29)	100,647,694,055.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(24,788,639,528.29)	100,647,694,055.30
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(7,906,243,764.23)	(7,906,243,764.23)
6	Өмчид гарсан өөрчлөлт	(10,335,379,940.03)				(10,335,379,940.03)
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,496,116,697.19	13,005,849,600.00	(32,694,883,292.52)	82,406,070,351.04
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				2,700,000.00	2,700,000.00
11	Залруулсан үлдэгдэл	99,598,987,346.37	2,496,116,697.19	13,005,849,600.00	(32,692,183,292.52)	82,408,770,351.04
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(8,802,518,492.75)	(8,802,518,492.75)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		896,855.04			896,855.04
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,497,013,552.23	13,005,849,600.00	(41,494,701,785.27)	73,607,148,713.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,407,866,058.94	26,751,286,889.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	23,178,498,640.37	26,518,670,498.98
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	23,900,584.00	24,066,264.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	205,466,834.57	208,550,126.02
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,566,673,535.40	25,302,396,307.79
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,211,065,622.65	3,686,845,000.39
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,080,896,447.82	885,041,660.69
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,246,851,143.92	7,775,264,275.25
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,981,539,911.94	4,240,053,535.44
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,514,437,921.76	6,344,549,114.17
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	27,846,575.34	7,226,301.38
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	937,421,544.57	990,137,898.67
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		8,607,670.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,566,614,367.40	1,364,670,851.80
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(158,807,476.46)	1,448,890,581.21
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	752,767.23	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	752,767.23	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	461,855,822.00	760,007,300.04
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	442,055,822.00	760,007,300.04
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	19,800,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(461,103,054.77)	(760,007,300.04)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	500,000,000.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	500,000,000.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	166,666,666.66	333,333,333.34
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	166,666,666.66	333,333,333.34
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	333,333,333.34	(333,333,333.34)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(286,577,197.89)	355,549,947.83
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	361,569,430.66	74,992,232.77
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	74,992,232.77	430,542,180.60

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
				Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Боловсруулсан ДЭХ	мян.Гкал	739.5	809.3	841.8	32.5	4.0
	Дотоод хэрэгцээний ДЭХ	мян.Гкал	13.2	13.2	14.0	0.8	5.9
	Дулаан түгээлт	мян.Гкал	726.2	796.1	827.8	31.7	4.0
2	Нийт орлого	мян.төг	21,197,207.2	22,147,508.0	24,219,889.5	2,072,381.5	9.4
	Үүнээс Үйл ажиллагааны орлого	мян.төг	21,004,734.5	22,007,930.9	24,058,669.4	2,050,738.5	9.3
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	192,472.7	139,577.0	161,220.1	21,643.0	15.5
3	Нийт зардал	мян.төг	28,747,513.5	31,096,587.9	32,779,116.4	1,682,528.5	5.4
	Үүнээс Удирдлагын зардал	мян.төг	224,920.7	151,697.2	138,166.8	(13,530.4)	(8.9)
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(7,550,306.2)	(8,949,080.0)	(8,559,226.9)	389,853.0	(4.4)
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	186.0	187.0	186.0	(1.0)	(0.5)
8	Нийт цалингийн сан	мян.төг	3,831.0	4,393.9	4,442.0	48.1	1.1
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	1,716,403.4	1,958,074.9	1,990,163.5	32,088.7	1.6
10	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төгрөг	39,584.2	39,061.2	39,596.1	534.9	1.4
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ЦЭХ	төгрөг				0.0	
12	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төгрөг	1.4	1.4	1.4	(0.1)	(3.6)
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	949.2	1,252.4	1,228.6	(23.9)	(1.9)
14	Нийт авлага	сая.төг	843.8	0.0	895.9	895.9	
	Үүнээс Найдваргүй	сая.төг	0.0	0.0	0.0	0.0	
15	Нийт өглөг	сая.төг	5,499.5	6,041.1	9,544.4	3,503.3	58.0
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	2,863.2	3,087.3	6,736.4	3,649.1	118.2
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	2,636.4	2,953.8	2,808.0	(145.8)	(4.9)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨХК/, түүний үйл ажиллагаа

Амгалан дулааны станц ТӨХК нь дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн зорилго нь Улаанбаатар хотын зүүн бүсийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр найдвартай хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах ажил үйлчилгээ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчийн хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс 30.0 хувийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, 70.0 хувийг Эрчим хүчний яам эзэмшиж байна.

3.2 Компани/ТӨХК/-ийн гадаад, дотоод орчин

Амгалан дулааны станц ТӨХК нь Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний салбарын хамтын хэлэлцээр зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 410 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 269 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”.
- “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол
- Амгалан дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/141 дугаар тушаалаар “Агуулахын журам”, “Эд хөрөнгийн тооллого явуулах журам”, “Эд хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бараа материал үнэ бүхий зүйлийн бүртгэл ашиглалт, хадгалалт хамгаалалтын журам”, “Бараа материал бэлтгэн нийлүүлэх орлогод авах, зарлагдах журам”
- Амгалан дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны А/84 дугаар тушаалаар “Мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулжээ.

Компани/ТӨХК/-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн ТУЗ нь тайлант онд 16 удаа хуралдаж, санхүү бүртгэл болон үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт, үүссэн хязгаарлалттай болон тулгамдсан нөхцөл байдлыг шийдвэрлэхээр 30 тогтоолыг хэлэлцэн баталсан байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 3 удаа хуралдаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж, 2022 оны зорилтот түвшин, их засвар, ТЗБАХ,

хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж зардлыг бууруулах талаар тодорхой асуудлыг хөндсөн 3 зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй үзлээ.

Дотоод аудитор тайлант онд төсөв төлөвлөгөө, үйлдвэрлэл, хангамж, хүний нөөц, архив бичиг хэрэг, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа болон худалдан авалт, ТБЗАХ, хөрөнгө оруулалтын чиглэлээр хяналтын 18 төрлийн ажлыг төлөвлөж, 100.0 хувийн биелэлттэй, тайлант онд нийт 13 зөвлөмж өгч, хэрэгжилтийг нь хянаж, тайлагнасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Амгалан дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/115 дугаар тушаалаар НБББББ-ийн тусгай бодлогыг боловсруулан баталсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй, дансны төлөвлөгөө нь шинэчилсэн санхүүгийн программтай уялдаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Амгалан дулааны станц ТӨХК-ний 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,754.0 сая төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	74,992.2	430,542.2	355,549.9
Авлага	843,835.6	895,799.7	51,964.1
Бараа материал	1,290,234.2	1,481,011.5	190,777.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	282,261.4	379,864.6	97,603.1
Үндсэн хөрөнгө	71,803,294.5	66,340,579.2	(5,462,715.3)
Биет бус хөрөнгө	13,097,154.1	13,074,698.9	(22,455.2)
Хойшлогдсон татварын хөрөнгө	513,825.6	549,088.9	35,263.2
Нийт хөрөнгө	87,905,597.6	83,151,584.8	(4,754,012.8)
Богино хугацаат өглөг	2,863,176.7	6,736,393.2	3,873,216.5
Урт хугацаат өглөг	2,636,350.5	2,808,042.9	171,692.3
Эздийн өмч	82,406,070.4	73,607,148.7	(8,798,921.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	87,905,597.6	83,151,584.8	(4,754,012.8)



Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан ашгийн данснуудад материаллаг дүнгээр өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 430.5 сая төгрөг болж 355.5 сая төгрөгөөр өссөн нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр УБДС ТӨХК-иас 420.0 сая төгрөгийн борлуулалтын авлага төлөгдсөн, 2023 оны 1 дүгээр сарын нүүрсний тээврийн төлбөр, урьдчилгаа цалин олгохоор тооцож, харилцах дансанд үлдээсэн мөнгөн хөрөнгө байна. Касс дах бэлэн мөнгө 3.9 сая, арилжааны банкны харилцах дансанд 426.6 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 895.8 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 51.9 сая төгрөгөөр өссөн байна. Авлага дансны үлдэгдэлд харилцагч байгууллага, хувь хүнээс авах авлага 696.1 сая төгрөг, ажилтан албан хаагчдаас авах авлага 25.6 сая төгрөг, НӨАТ-ын авлага 174.0 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,481.0 сая төгрөг болж 190.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрчим хүчний яамнаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу аюулгүйн нөөц бүрдүүлэх зорилгоор үндсэн сэлбэг материалын нөөцийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд худалдан авалтаар 14,411.5 сая төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгсэл, материал хангамж нэмэгдэж, 14,220.7 сая төгрөгийг зарцуулсан байна

Урьдчилж төлсөн зардал/тооцоо 379.9 сая төгрөг болж 97.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Амгалан дулааны станцыг 116 МВт хүчин чадалтай 1 зуухаар өргөтгөх төсөл “Шинэ сэргэлтийн бодлогын тухай хууль”-д тусгагдсаны дагуу техник, эдийн засгийн үндэслэл, барилга угсралтын тусгай зөвшөөрөл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 79,415.3 сая төгрөг болж 5,485.2 сая төгрөгөөр буурсан нь 1,118.6 сая төгрөгийн худалдан авалт хийж, тайлант жилд 6,603.8 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 1,118.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор 37.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулж, балансаас хасах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор 30 нэр төрлийн 74 ширхэг 44.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, 0.9 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон. Мөн 32 нэр төрлийн 61.4 сая төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 58 дугаар тогтоолоор акталж, данснаас хассан байна.

Богино хугацаат өглөгийн үлдэгдэл 6,736.3 сая төгрөг буюу өмнөх оноос 3,873.2 сая төгрөг буюу 2.3 дахин өссөн байна. Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд харилцагч байгууллагад өгөх 5,572.0 сая төгрөг, татварын өглөг 733.6 сая төгрөг, цалингийн өглөг 0.09 сая төгрөг, бусад богино хугацаат өглөг 106.2 сая төгрөг, НДШ-ийн өглөг 324.5 сая төгрөг буюу нийт 6,736.3 сая төгрөг байна. Харилцагч байгууллагад өгөх өр төлбөрийн 2,337.3 сая төгрөг буюу 41.9 хувь нь цахилгааны төлбөр, 2,859.5 сая төгрөг буюу 51.3 хувь нь нүүрсний төлбөр, 375.2 сая төгрөг буюу 6.8 хувь нь бусад харилцагч байгууллагад өгөх өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөрт Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулааны эрчим хүчийг найдвартай хангах болон 2015-2016 оны Улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд “Амгалан дулааны станц”-ын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлсэн үндсэн хөрөнгийг засгийн газрын буцалтгүй тусламжаар буюу хойшлогдсон

орлогын аргаар бүртгэснээс үүссэн 106.2 сая төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч, 799.5 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр, санхүүгийн тайлан, татварын зорилгоор байгуулсан элэгдлийн зөрүүгээс үүссэн 2,008.5 сая төгрөг, нийт 2,808.0 сая төгрөгийн өр байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК нь үйлдвэрлэл болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2022 оны А/21 дүгээр тушаалаар Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 22,400.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 30,481.8 сая төгрөгөөр, 8,081.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,312.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2022 оны А/132 дугаар тушаалаар нийт орлогыг 22,147.5 сая, нийт зардлыг 31,096.6 сая төгрөгөөр, алдагдлыг 8,949.1 сая төгрөгөөр тодотгосон байна.

2022 онд дулааны эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөг 31.7 мянган Гкал буюу 4.0 хувиар давуулан, 827.8 мянган Гкал дулааны эрчим хүч түгээн ажилласан байна.

Гүйцэтгэлээр 24,219.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 32,779.1 сая төгрөгийн зардал гарган, 8,559.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 24,219.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,072.4 сая төгрөг буюу 9.4 хувиар давсан нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 22 дугаар “Тариф батлах тухай” тогтоолоор 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн борлуулах дулааны үнийг /НӨАТ/-гүй 6,605.0 төгрөг/ГЖ-иар баталсан, “Амгалан дулааны станц”ТӨХК-ийг 116 МВт-ын хүчин чадалтай зуухаар өргөтгөхтэй холбоотой Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 444 дугаар “Тариф батлах тухай” тогтоолоор 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн борлуулах дулааны үнийг үе шаттайгаар нэмэгдүүлэх тариф баталсантай холбоотой байна. Үүнд:

- Эрчим хүч худалдах тарифт нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор төлөвлөснөөс 31.7 мянган Гкал дулааны эрчим хүч илүү түгээснээс 623.9 сая төгрөг;
- Тодотгосон төлөвлөгөөний дагуу нүүрс, цахилгааны зардлын нэмэгдлийг дулааны эрчим хүч худалдах тарифт нэмэгдүүлэн тусгаснаас 858.8 сая төгрөг;
- Тайлант оны 12 дугаар сард нүүрс, төмөр замын тээврийн үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор 568.0 сая төгрөг.

Нийт зардлын гүйцэтгэл 32,779.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,682.5 сая төгрөг буюу 5.4 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаад дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

- Дулааны эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөө 31.7 мянган Гкал өссөнөөр нүүрсний зарцуулалт 9 мянган тонн нэмэгдэж, 361.7 сая төгрөгөөр, нүүрсний үнийн нэмэгдлээс шалтгаалан 560.0 сая төгрөгөөр, дулаан гаргах чадвар /3,280-3,136 кг/Гкал/ 4.4 хувиар буурснаар 19.1 мянган тонн илүү зарцуулснаар 767.6 сая төгрөгөөр түлшний зардал нэмэгдсэн;
- Цахилгаан эрчим хүчний үнийн нэмэгдлээс шалтгаалан цахилгааны зардал 256.0 сая төгрөгөөр, дулааны эрчим хүчний түгээлт 31.7 мянган Гкал нэмэгдсэнээс 348.0 сая төгрөгөөр цахилгааны зардал нэмэгдсэн;
- Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор ээлжийн ажилтнуудын илүү цаг, шөнийн цагийн нэмэгдлийг дундаж цалин хөлснөөс тооцож олгосонтой холбоотой цалингийн зардал нэмэгдсэн.

Их засварын 5 нэр төрлийн 639.7 сая төгрөгийн ажил, техник зохион байгуулалтын арга хэмжээний 3 нэр төрлийн 74.0 сая төгрөгийн ажил, хөрөнгө оруулалтын 21 нэр төрлийн 538.8 сая төгрөгийн ажлуудыг төлөвлөж, 29 нэр төрлийн 1,228.6 сая төгрөгийн ажлыг 100 хувь гүйцэтгэж, гүйцэтгэлээр 90.2 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд 8,802.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөгөөт алдагдлыг 446.6 сая төгрөгөөр бууруулсан нь нийт орлого 2,072.4 төгрөгөөр нэмэгдэж, нийт зардал 1,682.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

ТӨБЗГ-т тайлант онд түрээсийн орлогын 40 хувь буюу 1.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК -ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани/ТӨХК/, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн ажил гүйлгээ гарсан тухай бүр гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах, ТӨБЗГ-н шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгө данснаас хасах, хувь хүнээс авах авлагыг тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл-Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Туяа, аудитор Ц.Отгонжаргал, аудитор Н.Пүрэвсүрэн, аудитор Н.Ганданбаавар, аудиторын туслах С.Наранцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар хэрэгжүүлсэн.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар болон Мэдээлэл-Аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн 28,233.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 423.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 317.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аж ахуй хангамж эрхэлсэн дэд захирлын орон тоог 2022 оны 06 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн бүтцийн өөрчлөлтөөр орон тоог хасаж цалингийн зардлыг 10.7 сая, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.5 сая, нийт 12.2 сая төгрөгийн бодит хэмнэлт гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь 100.0 хувийн биелэлттэй байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 337.7 сая төгрөгийн асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 134.7 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгасан байна. Биелэлт хангалтгүй 203.0 сая төгрөгийн 4 алдаа, зөрчлийг аудитын илрүүлэлт хэсэгт тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 231.2 сая төгрөгийн 3 албан шаардлага, 65.7 сая төгрөгийн 5 зөвлөмж өгснийг хянахад хэрэгжилт 90.0 хувийн биелэлттэй байна

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Албан шаардлага	3	231,208.7	3	231,208.7	100.0
2	Зөвлөмж	5	65,709.2	5	52,567.4	80.0
	Нийт дүн	8	296,917.9	8	283,776.1	90.0

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Амгалан дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/115 дугаар тушаалаар НБББББ-ийн тусгай бодлогыг боловсруулан батлан мөрдөж ажиллаж байгаа боловч дансны төлөвлөгөө нь санхүүгийн программтай бүрэн уялдаагүй байсан.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зорилтот түвшний тайланг бэлтгэхдээ 3.6 сая төгрөгийн зардлыг буруу ангилан тайлагнасан нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй 1 алдаа¹ илэрснийг завсрын аудитаар залруулсан.

Аудитаар нийт 207.3 сая төгрөгийн 6 зөрчил² илэрснээс 1.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 88.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 117.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 207.3 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 317.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс даваагүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Худалдан авалтын 2022 оны гэрээний хэрэгжилтийг шалгахад 6 бэлтгэн нийлүүлэгч /43-6.1, 53-4.2, 55-4.2, 28-4.1, 76-6.1, 77-4.1/-ийн гэрээний хоцорсон хугацааны хоног тутам 0.1 хувийн алдангийн 1.6 сая төгрөгийг бусад орлогоор тооцож бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, дээрх гэрээ тус бүрийн талуудын хүлээх хариуцлагад зааснаар гүйцэтгэгчийн буруугаас ажил, үйлчилгээний ажлын хугацаа хоцорсон хугацааны хоног тутам 0.1 хувийн алданги тооцно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний алдангийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. НБББББ-т тусгагдсан дүнгээс хэтэрсэн 84.4 сая төгрөгийг харилцагч байгууллагад бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн нь НБББББ-ын 7-д Мөнгөн хөрөнгийн удирдлага “Шаардлагатай үед буюу сар, улирал жилийн эцэст авлага өглөг бууруулах зорилгоор их хэмжээний буюу 300.0 сая хүртэлх борлуулалтын авлагыг УБДС ТӨХК-иас касст хүлээн авах, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад хуваарилах асуудлыг гүйцэтгэх захирал болон санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч шийдвэрлэнэ” гэж заасантай, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвшөөрөгдсөн дүнгээр бэлэн мөнгөний гүйлгээ хийх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

2. ТӨБЗГ-ын 2022 оны 277 дугаар тогтоолд заасан дүнгээс 4.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө илүү акталсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасахдаа холбогдох тогтоолын хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

2022 оны 3 дугаар сарын харилцахын 92 баримтыг түүвэрлэн шалгахад төлбөрийн даалгаврын дугаар бүгд 1 гэсэн ижил дугаараар дугаарлагдсан, цахим төлбөрийн баримтаар /И-баримт/ баталгаажуулаагүй 107.2 сая төгрөгийн гүйлгээ байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төлбөрийн даалгаврын дугаарлалтыг үнэн зөв бүртгэж, хяналт тавьж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, ажил, гүйлгээг гарсан тухай бүрд нь цахим баримтаар баримтжуулах.

2. Авлага данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн 2020 оны аудитаар илэрсэн 10.0 сая төгрөгийн төлбөрийн актыг буруутай этгээдээс авах авлагаар бүртгэсэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах

3. НБББББ-тай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

НБББББ-ийн дансны төлөвлөгөөг санхүүгийн программтай уялдуулаагүй нь Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-тай нийцээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

НБББББ-т дансны төлөвлөгөөг шинэчилсэн санхүүгийн программтай уялдуулж сайжруулалт хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/													
Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зорилтот түвшний тайланг бэлтгэхдээ 3,606.0 мянган төгрөгийн зардлыг ангилал гүйлгэж тайлагнасан	1	3,606.0			1	3,606.0	1	3,606.0				
	Дүн	1	3,606.0			1	3,606.0	1	3,606.0				

/мянган төгрөгөөр/

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Худалдан авалтын 2022 оны гэрээний гүйцэтгэлд 6 гэрээний нийлүүлэлтийн хоцорсон хугацааны хоног тусам 0.1% алдангийн 1,570.3 мянган төгрөгийг бусад орлогоор тооцож бүртгээгүй байна	1	1,570.3	1	1,570.3								
2	НБББББ-т баримтад тусгагдсан дүнгээс 84,433.0 мянган төгрөгийн бэлэн мөнгийг нярав хүлээн авч	1	84,433.0			1	84,433.0						

/мянган төгрөгөөр/



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 дугаар сарын 21 № 104/АД/50124

Улаанбаатар хот

СНАГ-2023/93/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Амгалан ДЦС ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авалтын 2022 оны гэрээний хэрэгжилтийг шалгахад 6 бэлтгэн нийлүүлэгч /43-6.1, 53-4.2, 55-4.2, 28-4.1, 76-6.1, 77-4.1/-ийн гэрээний хоцорсон хугацааны хоног тутам 0.1 хувийн алдангийн 1,570,331.0 (нэг сая таван зуун далан мянга гурван зуун гучин нэг) төгрөгийг бусад орлогоор тооцож бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 2022 оны 43-6.1, 53-4.2, 55-4.2, 28-4.1, 76-6.1, 77-4.1 дугаар гэрээ тус бүрийн "талуудын хүлээх хариуцлагад зааснаар гүйцэтгэгчийн буруугаас ажил, үйлчилгээний ажлын хугацаа хоцорсон хугацааны хоног тутам 0.1% алданги тооцно" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гүйцэтгэгчээс суутган тооцоогүй 1,570,331.0 төгрөгийн алдангийг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Амгалан ДЦС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Мөнхөө, ерөнхий нягтлан бодогч Ө.Удвал нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД

Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Багд тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2023\0215 SNAG-15.Docx

0001090043



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 406 /А.0150124

Улаанбаатар хот

СНАГ-2023/93/МБ-СТА-ТӨД

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Амгалан ДЦС ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор зөвшөөрөгдсөн дүнгээс 4,114,156.2 төгрөгийн үндсэн хөрөнгийг илүү акталж, данснаас хассан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2-т заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор зөвшөөрөгдсөн дүнгээр акталж байх албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан ДЦС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Мөнхөө, ерөнхий нягтлан бодогч Ө.Удвал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД

Д.ТОВУУДОРЖ



0001080897



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 404/А0150124

Улаанбаатар хот

СНАГ-2023/93/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Амгалан ДЦС ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан дүнгээс хэтэрсэн 84,433,000.0 төгрөгийг кассанд бэлнээр авч гүйлгээ хийсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 7-д Мөнгөн хөрөнгийн удирдлагад "Шаардлагатай үед буюу сар, улирал жилийн эцэст авлага өглөг бууруулах зорилгоор их хэмжээний буюу 300.0 сая хүртэлх борлуулалтын авлагыг УБДС ТӨХК-иас касст хүлээн авах, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад хуваарилах асуудлыг гүйцэтгэх захирал болон санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч шийдвэрлэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээний дээд хязгаарыг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Амгалан ДЦС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Мөнхөө, ерөнхий нягтлан бодогч Ө.Удвал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
Ч БОЛД
Д ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0315 SNAG-20.Docx

0001080895